



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 103

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 84 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:


Нэг: Төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 7,340,000 /долоон сая гурван зуун дөчин мянга/ төгрөгийн өртөг бүхий ажилчдын амрах байр, 781,000 /долоон зуун наян нэгэн мянга/ төгрөгийн өртөг бүхий худгийн барилгыг Сум дундын ойн ангийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Сум дундын ойн ангийн дарга (Ц.Галбадрах)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  СОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 07 дугаар сарын  
22-ний өдрийн 123 тогтоолын хавсралт



Сум дундын ойн ангийн үндсэн хөрөнгөд бүртгэх барилгын мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжээ /м/кв/	Тоо ширхэг	Бүртгэлд тусгах үнэ
<b>Барилга байгууламж</b>				
1	Ажилчдын амрах байр	24	1	7,340,000
<b>Барилга байгууламжийн дүн</b>				<b>7,340,000 /долоон сая гурван зуун дөчин мянга/</b>
2	Худгын барилга	6	1	781,000
<b>Барилга байгууламжийн дүн</b>				<b>781,000 /долоон зуун наян нэгэн мянга/</b>